

ТҮРЭГ УГСААТНЫ ХҮН ЧУЛУУ ХӨШӨӨНИЙ УРЛАГ /МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙГАА ХӨШӨӨНИЙ ЖИШЭЭН ДЭЭР/

*М.Хурметхан**

Төв Ази нь хүний соёл иргэншлийн нэгэн голомт-хүний оюун, гараар бүтээсэн дурсгалт зүйлээр баян билээ. Биет зүйл нь шинжлэх ухаан, урлаг судлалын чухал хэрэглэгдэхүүн болдог бөгөөд түүний өвөрмөц нэгэн зүйл нь чулуун хүн хөшөө юм. Төв Азид нийт 2000 илүү хүн чулуун хөшөө бүртгэгдсэн бөгөөд тэдгээрээс 500 орчим нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагийн дийлэнх олонхи нь түрэг угсаатны хүн чулуун хөшөө юм.

Төв Азийн нүүдэлчдийн түүх, угсаатны нутгийн тархалт, угсаа гарал, зан заншил, шүглэг, галбирь төрх, зэр зэвсэг, ертөнцийг үзэх үзэл, дүрслэх урлагийн талаар эдгээр хүн чулуун хөшөөнүүд тодорхой хэмжээний мэдээлэл агуулдаг. Эдгээр нь түүхэн тулгар сурвалж төдийгүй дүрслэх урлаг, уран сайхны хөгжлийг илтгэн харуулж байгаагаараа онцлог юм.

Түрэгүүд хүн чулууг гантиг буюу боржин чулуугаар урлан хийж тахилын онгоны цогцолбор байгууламжийн бүрэлдэхүүнд оруулан босгодог байв. Түрэг угсаатны хүн чулуун хөшөө Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт тархсан байх боловч Баруун, Төв, Умарт хэсгээр зонхилох ба Баян-Өлгий, Ховд, Увс аймаг, Орхон, Туул, Хануй, Тэрх, Хэрлэн, Онон, Түйн голын саваар байрлажээ.¹ Эдгээр нь VI-XIII зуунд оршин сууж байсан түрэг угсаатан хүн амын үлдээсэн соёлын дурсгал юм.² Эдгээр хүн чулуу хөшөөг түрэг угсаатны мандсан төр улсуудын нэр суут хаад, жанжин нарт зориулан босгож байсан бөгөөд Дорнод Түрэгийн хаант улсын нэн их эрч хүчийг аваад ид цэцэглэж байсан үетэй холбогдохын хамт түүнээс өмнөх болон дараах үеийг нэгэн адил хамаарна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт тэмдэглэгдсэн хүн чулуун хөшөө нэг дор нэг цогцолборт байхаас гадна онцгой том цогцолборуудад бол хэдэн арваараа ч хамт байдаг. Тухайлбал, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Өнгөтийн цогцолборт 28 хүн чулуун байгаа бол Күльтегиний цогцолборт 10, Билгэ-хаан, Тоньюкукийн цогцолборт 9-4 хүн чулуу байх ажээ. Эдгээр нь олон зуун жил өнгөрөөд ихээхэн нь үрэгдэж алга болсоны дараах байдал юм. Энэ нь түрэг угсаатнууд өөрийн түүхэндээ олон мянган хүн чулуун хөшөө бүтээн босгож байсныг гэрчилдэг байна. Хүн чулуун хөшөөнүүдийн зарим нь нилээд сайн хадгалагдсан бөгөөд ихэнх нь тухайн дурсгал анх байгуулагдсан газартаа байгаа ажээ. Монголын төв нутагт гэхэд түрэгийн хүн чулуу

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

38 бүтэнээр уламжлагдан ирсэн бөгөөд эдгээр нь муу хийцтэй нь юм байна.³

Харин эдгээр хүн чулуунуудийн олонхи нь эвдэрч гэмтсэн нь хүний зориудын үйл ажиллагаа юм уу байгаль- экологи, цагийн хүчин зүйл, хүн чулуу хөшөөний хийц, босгосон чулууны бүтэцтэй холбоотой байжээ. Тухайлбал, Билгэ хаан, Күльтегиний цогцолбор нь XIII зууны үед бүтнээр байсан тухай Г.Е.Грум-Гржимайло түрэг судлаач Девернагаас иш татан мэдээлсэн байдаг.⁴ Мөн Францын нэрт аялагч Буяиа до Лакат /1867-1937/ нь 1909 онд Монголд ирэхэд Хөшөө Цайдам дахь гэрэлт хөшөөнүүдийг туйпуугаар хамгаалсан ба зарим хүн чулуу хөшөө босоогоор байгаа нь түүний фото зургаас харагдана. Ер нь хүмүүс зөвхөн хүн чулуу, адгуусны барималын толгойг хэмх цохиж байсан гэхэд нь үнэмшилгүй бөгөөд Билгэ хаан, Күльтегин, Тоньюкукийн сүрлэг хөшөө нь мөн тэнд байж, бараг муу үйлдэлд өртөлгүй бидэнд уламжлагдан ирсэн, харин цаг хугацаа, экологийн хүчин зүйл элээсэн нь үнэн билээ. Түрэгийн хүн чулуун хөшөө нь хамгийн их ур чадвар гарган бодит байдалд нэн дөхүү урласан 66 хөшөөний толгой хэмхэрч устсан байна. Энэ нь хүн чулуун хөшөөний толгойн хэсэг том, жин нь хүнд /Күльтегиний хөшөөний толгойн өндөр 41 см, өргөн 20 см, зузаан 21 см/ байгаа нь нарийн хийцээр урласан хүзүүний хэсэг нарийхан байх тул цагийн уртад чулууны бүтэц гэмтэлд орж, улмаар байгалийн нөлөөгөөр /газар хөдлөлт гм/ тэдгээр нь нэгэн зэрэг юм уу дараалан хугаран унасан бололтой. Харин хийц муутай хүзүүний хэсэг зуузан /Чойр, Даян баатар гм/ урласан хөшөөнүүд бүрэн бүтэн байгаа нь үүнийг гэрчилж байна. Хэмжээгээр бага, өмнө нь хүний үйлдэлд өртсөн, газар унасан толгойн хэсэг нь чулууны чанар зэргээс шалтгаалан зарим нь устаж, зарим нь үлджээ.

Хүн чулуу хөшөө хэмээх нь боржин, гантиг, элсэн чулуу, занар, хүрмэн чулуун цогцолборлон урлахад эвтэй тухайн нутаг оронд элбэг янз бүрийн ур хийцтэйгээр урлан бүтээсэн хөшөө юм. Эртний түрэгүүдийн хувцас хунар, гээг үсний хэлбэр, зарим эдлэл хэрэглэл, гоёл чимгийн зүйлсийг тодруулан судлах нэгэн гол сурвалж нь хүн чулуу хөшөө юм. Түрэг угсаатнд холбогдох хүн чулуу 500 гаруйг илрүүлэн бүртгээд байгаа ба цаашид ч нэмэн олох боломжтой. Ийм төрлийн дурсгалыг Алтай, Тува, Дундад Ази, Казахстаны нутгаас эрдэмтэд их хэмжээтэй олж судлан тодорхойлж эрдэм шинжилгээний олон бүтээл нийтэлжээ. Эдгээрийг босоо байдалтай буюу завилж, эсвэл сөхрөн суусан байдлаар урлах боловч ихэнх хүн чулуунд хөл дүрсэлдэггүй, баруун гарт нь сав суулга бариулж, зүүн гараар бүснээс зүүсэн сэлэм буюу хутганы ишийг атгасан байдалтай урлан хийнэ. Эдгээр хөшөөнд хувцас, бүс, зэр зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлсийг

нарийн тодорхой сийлбэрлэн гаргасан байдаг нь түүхэн сурвалжийн мэдээ болон малтлагаар олдсон эд өлгийн зүйлстэй тэдгээрийг харьцуулж он цагийг нь нарийвчлан тодотгох боломж олгодог.

Хүн чулуун хөшөө хийгээд дүрслэх урлагийн бусад төрлийн дурсгалуудаас үзэхэд түрэг гарвалын угсаатнууд нь буруу энгэртэй, хоёр тийш эргэдэг өргөн захтай дээл өмсөх ба төмөрлөг товруу, олон унжлага бүхий агсрага бүс бүсэлдэг байжээ. Энэхүү бүсний хийц байдлыг хүн чулуунд гаргасан дүрслэл хийгээд булшны олдвор зэргээс тодотгон мэдэж болох юм. Зэр зэвсэг, хавтага сав зэрэг эд юмсыг зүүж унжуулахад зориулсан суран унжлага тогтоох нүхтэй дөрвөлжин товруунаас гадна тал саран, бундан эсвэл захаараа хээтэй дүгрэг гэх мэт олон төрөл хэлбэрийн товруугаар бүсээ чимэглэдэг байсан бөгөөд ийм бүсний үлдэгдэл зөвхөн эр хүний булшнаас олдог байна. Толгой нь бүтэн үлдсэн хүн чулуудыг ажиглахад өнөөгийн казах нэн төстэй өргөн шанаатай том нүдтэй байх бөгөөд нэлээд тохиолдолд махирлаж эргүүлсэн живэр сахалтай байдаг. Толгойн үсээ урт ургуулж ганц буюу олон салаа гэзэг гөрж унжуулдаг байжээ. Гэзэг үсний хэлбэр ийнхүү янз бүрийн байгаа, тэрчлэн зарим хүн чулуунд зөв энгэртэй дээл дүрсэлсэн байдаг зэрэг нь уг хөшөөг өөр өөр цаг үед босгож байсны шинж тэмдэг бололтой. Түрэгүүд хөлдөө өсгийгүй, хөнгөн арьсан гутлыг эсгий оймстой өмсөх ба шагайн орчим суран боолтоор боодог байсан нь малтлагын олдвор хийгээд зарим хүн чулууны дүрслэлээс мэдэгддэг юм. Гоёл чимэглэлийн зүйлсээс бөөрөнхий унжлагатай, жижиг цагирган сэнжтэй ээмэг элбэг олддог байна. Эмэгтэй хүний булшнаас хүрэл толь, модон сам зэрэг зүйлс гардаг.

Түрэг угсаатны эртний дурсгалууд дунд хөшөө хад чулуунаа сийлж үлдээсэн тамга тэмдэг чухал байр эзэлдэг юм. Ялангуяа, түрэг угсаатны язгууртаны тамга дардас дээр зогсож байгаа янгирыг хажуугаас сийлсэн байдаг. Үүнд, Күльтегин, Алтан Тамган Тарханы хөшөөний дээд толгой болон бусад хэд хэдэн хаданд бий бөгөөд “Хаан төрийн билэг тэмдэг” юм. Мөн түрэг угсаатны гэрэлт хөшөөг маш уран хийц бүхий мэлхий дүрстэй чулуунд суурилуулан, Күльтегиний хөшөөний орой ч эвхэрсэн хоёр луугаар чимэглэж, чулуун бодь гөрөөс, хуц зэрэг баримал байна.

Түрэг угсаатнууд бусад нүүдэлчдийн адил эсгий гэрт суух ба зарим суурьшмал хүн ам бүхий нутагт байнгын сууц барин суудаг байсан бололтой. Нүүдэлчдийн эсгий гэрийн тухай эртний нангиадын их яруу найрагч Бо-Цюй яруу сайхан шүлэглэн бичсэн байдгаас гадна хаад язгууртны алтан чимэг тавилга, торгон бүрээс бүхий тансаг сайхан өргөө гэрт орж үзсэн тухайгаа Түрэгийн хаанд бараалхсан Византийн элч Менадр тэмдэглэн бичжээ.

Түрэг угсаатнуудын хүн чулуун хөшөөний дүрслэлийн ур чадвар харилцан адилгүй бөгөөд зарим хөшөөг үнэхээр уг хүний жинхэнэ дүр төрхийг үнэн бодитой тусган тун уран нарийн урласан байдаг. Ийм хөшөөний жишээнд Хөшөө Цайдамын малтлагаас олдсон Билгэ хаан, түүний хатан, Күльтегин, түүний хатны хөрөг, Баян-Өлгийн нутагт байгаа Даян баатарын⁵ хөрөг зэрэг батлан харуулж байгаа юм юм.

Күльтегиний цогцолборын хойморт шүтээний сүм байрлаж, Күльтегин, хатныг нь завилан суугаа байдлаар нэн чадамгай сийлбэрлэн урлаж зэрэгцүүлэн залсан байжээ. Сүмийн үүднээс цогцолборын зүүн өмнөд хэсэгт байх гэрэлт хөшөө хүртэлх зайнд шадар дагалт, ноёд нарын суугаа босоо чулуун хөргийг хоёр эгнээ гудамгалан өөд өөдөөс нь харуулж байрлуулжээ. Мөн Билгэ хаан, Тоньюкук, түрэг угсаатны бусад томоохон дурсгалууд ч мөн ийм байрлалтай байжээ. Завилсан босоо, сөхөрсөн, цоомшойн суусан байдлаар эзэн албатын ёс заншлыг нарийн тусгажээ. Тухайлбал, зарим томоохон хөшөөнүүдэд дараах байдалтай юм.

Нэр	Завилан суусан	Сөхрөн суусан	Босоо	Бүгд
Билгэ хаан	2 /нэг эмэгтэй/	1	1	7
Күльтегин	2	2	6	10
Тоньюкук	1	--	3	4
Онгийн гол	1	4	-	5
Хуц уханагай	1	1	Тодорхой биш	-
Улхын булаг	1	1	1	-

Билгэ хааныг цагаан гантигаар дүрслэхдээ, дөрвөн дэлбээт цэцгэн хэлбэртэй товруу хадсан бүстэйгээр хийсэн бол хатных нь хөшөөг том суурьтай бөгөөд товгор хөх, нарийхан бэлхүүс, уран зөөлөн дүрсэлжээ. Билгэ хаан, Күльтегиний хүн хөшөөнүүдэд ихээхэн хүмүүсийг тэдний бодол сэтгэл нүүр, бие, өмссөн хувцас, дэв зиндаа нь харилцан адилгүй бодитойгоор дүрсэлжээ. Балбал дотор хүн чулуу дүрстэй байдаг нь ёслолд оролцсон хамгийн өндөр албан тушаалтан хүний дүрс юм. Балбал 20-1000 хүрч байдаг нь оршуулах ёслолд оролцсон хүний тоо биш, зөвхөн айл, отог, омог, аймгаас оролцсон төлөөллийн тоо байдаг юм. Тухайлбал Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт буй Өнгөтийн хөшөөний балбал нь 2 км үргэлжилж, 552 чулуу мэдэгдэх ба эхний 2 чулуу хүн дүрстэй юм.

Хөл Асгатын буюу Алтан Тамган Тарханы хөшөө нь хэл, түүхийн төдийгүй түрэг угсаатны ард түмний эд, оюуны соёлын ололтыг илтгэн харуулсан, өндөр ур хийц, дүрслэл бүхий дурсгал юм. Уг хөшөөг 1893 онд ургамал зүйч Н.П.Левин олж, В.Радлов судласан юм. Зүүн зүг харсан хөшөөний нүүрэн талд гурван суумал хүнийг товойлгон сийлж, зүүн дээд өнцөгт түрэгийн хаадын тамга, доор нь бүргэд сийлжээ.

Хөшөөний чулуун хормойг эрвэн хээ чимжээ. Эртний түрэгүүдийн гарал үүслийн талаархи домог зөвхөн аман болон бичгийн хэлбэрээр⁶ төдийгүй дүрслэг урлаг хөшөөний байдлаар уламжилагдан ирсэнийг Архангай аймгийн музейд буй хөшөө илтгэн харуулж байна. Баян-Өлгий аймгийн Даян нуурт түрэгийн үеийн сонгодог хүн чулуун хөшөө байгаа ба энэ нь Хөх Түрэгийн хаант улсыг үндэслэгч Буман хааны дурсгалд зориулсан хөшөө бололтой. Учир нь уг хөшөө том үйл хэргийг бүтээсэн хүнд зориулагдсан ба хүзүүнд шувуу /бүргэд/ сахиус дүрсэлсэн байна. Саарал өнгийн чулуугаар нарийн урлан хийжээ. Өндөр нь 1,6 м, өргөн нь 38 см. Түрэгжүү царайтай хөмсөгтэй живэр сахалтай, уруул нимгэн, чих нарийн дугариг, товч бүхий цагираган ээмэгтэй, хүзүүнд бүдүүн осортой бүргэд тэмдэг зүүжээ. Энгэрийн зүүнээс баруунаа даруулан уясан мөрөвчтэй, мөрөвчийн үзүүрийг бүстэй холбожээ. Бүсний доор чагталсан оосортой байна. Энэ нь түрэг угсаатнууд малгай, титэмд бүргэд юмуу домгийн шувуу дүрсэлж, бугын тэмдэг зурж мэлхий, арслан, хонь, чононы дүрс баримал хөшөө босгодог байсны нэг жишээ юм.⁷ Тухайлбал, Билгэ хааны онгоны хэсгийн баруун хойт талд хоёр хонь баримал байна.

- урьд талын хуц суурьтай 91x89x43 см толгой нь хагарч алга болсон, шаргал боржин чулуугаар хийсэн,

- хойд талын хуц хөх саарал өнгийн боржин чулуугаар хийсэн толгойн хүзүүгүй, 96x66x43,5см эдгээр хонины хөшөөдийг хэвтээгээр урлажээ. Мөн түрэгийн хонины дүрс баримал олон бий.

- Билгэ хааны онгоноос гарсан мэлхий чулуун баримлыг цагаан гантигаар хийжээ. Урт нь 224 см өргөн нь 150 см, өндөр нь 78 см байна. Мэлхий чулууг маш нарийн ур хийцтэй үйлдсэн нь бүх биеийн ерөнхий харьцаа, гадаргыг өнгөлсөн, хөл болон хөлийн хумсыг гаргасан байдлаас ажиглагдана. Түрэгийн мэлхий хөшөөний тухай Д-р Камил Угурлу судлан бичсэн билээ.⁸ Боржин чулуу арслан, бодь гөрөөсийн баримал бас байна.

- Билгэ хааны алтан титэм нь нүүр талдаа домгийн шувуу дүрсэлсэн амандаа эрдэнийн улаан чулуу зуусан байдалтайгаар урлажээ. Бусад хоёр талыг хээгээр чимэглэн, эрдэнийн чулуу чигтгэж байсан бололтой суурьтай юм.

Эдгээр байдлаас үзэхэд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түрэг угсаатны соёлын нэгэн чухал ололт-хүн чулуун хөшөө баялаг хадгалагджээ. Тэдний дүрслэх урлагийн өв нь тун их ур ухаан, хөдөлмөрөөр гоёмсог сайхан бүтээсэн, нэр цуут хаад, ихэст зориулсан цогцолбор, олон хүн амьтны дүрсийг багтаасан байна. Тэдгээрийг бүтээхэд түрэг угсаатан өөрийн оюун ухаан, урлагийн уламжлалаас гадна өрнө, дорнын соёлын нөлөө тусч, улмаар эргэн тойрондоо

өөрийн нөлөөлөл хүргэсэн нь үзэгдэнэ. Эдгээр хөшөө нь эд өлгийн ба утга соёлын дурсгал төдийгүй манай өвөг дээдсийн уран ухаан, уйгагүй хөдөлмөрөөр бүтсэн урлагийн бүтээл болохын хувьд дүрслэх урлагийн алтан санд зүй ёсны байр эзэлнэ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. А.Д.Грач. Центральная Азия как историко-археологический регион. История и культура Центральной Азии М., 1983. Л.А.Евюхова. Каменные изваяния южной Сибири и Монголы МИА №24 М., 1952 с. 72-120. Итс. Р.Ф. О каменных изваяниях в Синьцзяне СЭ. 1958. №2. В.Д.Кубарев. О древнетюркских оградах Восточного Алтая. Новое в археологии Новосибирск 1979.с.135-160 Древнетюркские изваяния Алтая. Новосибирск., 1984. Я.А.Шер. Каменные изваяния Семиречья. М-Л., 1966. В.В.Радлов. Атлас древностей Монголии Вып I. 1892 т. Вып. II 1893, Вып III 1896, Вып IV 1899, Сборник трудов Орхонской экспедиции. Спб. Вып I, 1892, Вып. II 1895, Вып III 1897, Вып IV 1897 Вып V, 1901. Т.Баяр. Монголчуудын чулуун хөрөг / XIII-XIV/ УБ. 1995 Д.Баяр Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу УБ, 1997 Д.Баяр Д.Эрдэнэбаатар Монгол Алтайн хүн чулуун хөшөө УБ, 1999
2. Х.Ислам. Казах кауымы А., 1997, б.95-120 Ныгмет Мынжан Казактын кыскаша тарихы А., 1994 б. 156-193 Эдгээр чулуун хөшөөнүүд Хөх Түрэг, Уйгур, Киргисын хаант улсын үе түүний дараа оршин тогтнож байсан Керей, Найманы ханлигийн үед мөн холбогдоно.
3. Д.Баяр. Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу УБ, 1997 т.7
4. Г.Е.Грумм-Гржимайло. Западная Монголия и Урянхайский край.Т.2.,Л.,1926
5. Liu Mau-tsai.1969vol.I.c.40. vol 2.c.488.
6. Восточный Туркестан в древности и раннем средневековье.М.,1992.с.124. С.Г.Кляшторный, Левшиц Открытие и изучение древнетюркских и согдийских памятников Центральной Азии. Новосибирск.1978.
7. БжЕ.1984.№2.,б.19-21
8. Güçtürk Devletinin 1450 kuruluş Yılıymu. Ankara.2001. pp 87-102